

**БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2023.12.30

Баян-Өндөр сум

Д/д	Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	Хугацаа	Хамрах хүрээ	Биелэлт/хувь	Хяналт үнэлгээ
3.1 Албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд:					
1.	3.1.1.Ажлын байрыг оффисын зохион байгуулалтад оруулж, албан хаагчид өрөөнд сууж ажиллах чиглэлээр өрөөг засах, дуу чимээ, чийгшилтээс хамгаалж хөдөлмөрийн хэвийн нөхцлийг бүрдүүлэх;	жилдээ	Байгууллагын албан хаагчид	А заалны мэргэжилтнүүдийн өрөөний хулдаасыг сольж 260,000 төгрөг, Б зааланд ажилладаг 5 албан хаагчийн ажлын өрөөнд засвар үйлчилгээ хийж 3,900,000 төгрөг, өрөөний гэрэл шинэчлэхэд 200,000 төгрөг, А зааланд 2 өрөөнд засвар 970,000 төгрөг, нийт 5,330,000 төгрөг зарцуулсан байна. 100%	
2.	3.1.2.Байгууллагын дотоод үйл ажиллагаанд интернэт сүлжээ болон хурдыг сайжруулах, цахим группээр албан хаагчдыг мэдээллээр хангах, ажилтнуудын мэдээлэл солилцох ажиллагааг хөнгөвчлөх;	жилдээ	Ажлын цагаар ажиллаж байгаа ажилчид	Албан хаагчдын дотоод үйл ажиллагаанд цахимаар ажиллах нөхцөл хангагдсан байна. Ажлын байран дээр ажиллаж байгаа 18 ажилтан хамрагдаж байна. 100%	
3.	3.1.3.Албан хаагчдын өрөө тасалгаанд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай компьютер, хэвлэх, хувилах тоног төхөөрөмжөөр хангах;	жилдээ	Шаардлагатай албан тушаалтангууд	Нийт байгууллагын хэмжээнд өнгөт принтер 4ш, хар принтер 5ш албан хэрэгцээнд ашиглагдаж байна. 4 дүгээр улиралд албан ажлын хэрэгцээнд шинээр суурин компьютер 3ш, нөүтбоок 1ш, 3 үйлдэлтэй принтер 3 ш, нийт 14,600,000 төгрөгийн техник хэрэгсэл худалдан авсан байна.	

				100%	
4.	3.1.4.Албан хаагчдын өрөө тасалгаанд шаардлагатай ширээ, сандал, шкафаар хангах;	жилдээ	Шаардлагатай албан тушаалтангууд	Албан хэрэгцээнд ширээ 6ш 3,240,000 сандал 23ш 3,689,000 шүүгээ 8ш 7,568,000 угтах үйлчилгээний хэсэг 2ш 5,000,000 төгрөг нийт 19,497,000 төгрөг зарцуулсан байна.	100%
5.	3.1.5.Ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах хэвлэх хувилах тоног төхөөрөмжийн хор цэнэглэх засвар үйлчилгээг тухай бүр хийх бичгийн хэрэгсэл бусад зүйлсээр хангах;	жилдээ	албан тушаалтангууд	Нийт байгууллагын хэмжээнд өнгөт принтер 3ш, хар принтер 3ш албан хэрэгцээнд ашиглагдаж байсанаас тайланд онд принтер 5ш 5,086,000 нөтбүүк 2,999,000 компьютер 9,195,000 нийт 17,280,000 төгрөгийн техник хэрэгсэл худалдан авсан байна.	100%
6.	3.1.6.Албан ажлын дотор болон гадна орчинд ажил үүргээ гүйцэтгэх зориулалтын хувцсаар үе шаттай хангах;	жилдээ	Үйлчилгээний албан хаагчид	Ажиллагсдын ажлын хувцсыг 2023 оны 10 дугаар сард 934,000 төгрөгийн нормын хувцас шинэчилсэн.	100%
7.	3.1.8.Ажлын байрны орчин нөхцөл, цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах; (халаалт, гэрэлтүүлэг, өрөөний тохижилт, цахилгаан хангамжийн үйлчилгээ, гэх мэт);	жилдээ	Албан хаагчид	Байгууллагын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх зорилгоор А, Б зааланд нийт 1,574,000 төгрөгийн ажил хийсэн байна.	100%
8.	3.1.9.Албан үүргээ гүйцэтгэх үед албаны унаагаар хангагдах эсхүл гарсан зардалд нөхөх олговор олгох;	жилдээ	Албан хаагчид	Албан үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн унаагаар албан үүргээ үйцэтгэж буй албан хаагчдад бензин талон өгч ажилласан. Нийт 4 албан хаагч хамрагдаж 20,000-50,000 төгрөгийн бензин талон давхардсан тоогоор 2-3 удаа авсан байна. Нийт 1,250,000 төгрөг олгосон байна.	100%

9.	3.1.10.Албан үүргээ гүйцэтгэж байгаатай холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх, бэлгийн дарамт үзүүлэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авах;	жилдээ	Албан хаагчид	Албан үүргээ гүйцэтгэж байгаатай холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх, бэлгийн дарамт үзүүлэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга талаар ҮЭХ-той хамтран нийт 10 удаагийн мэдээлэл хүргэсэн байна. 100%
3.2.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилтын хүрээнд:				
10.	3.2.1.Ажилтан албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор спортын А зааланд Лхагва гаригт 2 цагаар тоглох заалаар хангах, нийт албан хаагчдыг хамарсан уралдаан тэмцээн, биеийн тамир, спортын арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах;	жилдээ	Албан хаагчид	Байгууллагын ажилчдын бие бялдрын хөгжүүлэх, чийрэгжүүлэх зорилгоор А зааланд 7 хоног бүрийн Лхагва гаригийн 16.00-18.00 цагуудад чөлөөт тоглолтын хуваарийг батлуулсан. 03, 10 дугаар сард албан хаагчдын дунд 4 төрөлт тэмцээнийг 4 багт хуваан 2 удаа зохион байгуулаад байна. Тэмцээний зардалд 1,000,000 төгрөг зарцуулсан байна. 100%
11.	3.2.2.Байгууллагатай хамтран ажиллаж буй фитнес, клубуудэд албан хаагчдыг фитнес, иогоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх;	жилдээ	Албан хаагчид	Байгууллагатай хамтран ажиллаж буй фитнес, клубуудэд албан хаагчдыг фитнес, иогоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх 3 фитнес, клубтай хамтран ажиллах гэрээг 10 дугаар сард батлуулсан. 100%
12.	3.2.3.Ажилчдын амрах таатай нөхцөлийг бүрдүүлж, Монгол орны үзэсгэлэнт газруудаар жил бүр 1 удаа аялуулах;	09-10-р сард	Албан хаагчид	Хэнтий аймгийн Чингис хотод зохиогдсон Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдын урлаг, спортын Улсын анхдугаар зөвлөгөөн 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс 08 дугаар сарын 05-ны өдрүүдэд нийт 8 албан хаагч оролцож 3,717,400 (гурван сая долоон зуун арван долоон

				мянга дөрвөн зуу) төгрөг зарцуулсан байна. 100%	
13.	3.2.4.“Эрүүл агаар-эм”, “Цасны баяр” зэрэг идэвхитэй амралт, явган болон тойрон аялалыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах;	01, 05, 10-р сард	Албан хаагчид	Ажлын ачааллын улмаас 10 дугаар сард нийтийн биеийн тамирын албанаас албан хаагчдын дунд өдөрлөг хэлбэрээр зохион байгуулж, олс таталтын тэмцээнийг явуулсан. 100%	
14.	3.2.5.Албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг жилд 1 удаа зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамруулах;	улиралд	холбогдох ажилчид	Иргэдийг үзлэгт хамруулах график төлөвлөгөө гаргасан,эрт илрүүлэг үзлэг, оношилгоо бүтэн жилийн турш явагдахтай холбогдуулан албан хаагчдыг тухай бүр ажлаас нь чөлөөлж үзлэгт бүрэн хамруулахаар шийдвэрлээд байна. 46-60 насны даатгуулагчийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц, шинжилгээнд ЭМГ-тай хамтын ажиллагааны хүрээнд 11 дүгээр сард нийт 17 албан хаагчийг хамруулсан байна. 100%	
3.3.Албан хаагчдад цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэмж олгох, шагнаж урамшуулах ажлын хүрээнд:					
15.	3.3.1.Холбогдох хууль, тогтоомжийн дагуу албан хаагчийн цалин болон нэмэгдлийг тухай бүр шинэчлэх, шаардлагатай төсвийг холбогдох дээд байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх; урамшуулах;	жилдээ	Албан хаагчид	Даргын 2023.02.01-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар төрийн захиргааны албан хаагчийн орон нутагт ажилласны нэмэгдэл 20%-ийг 2 албан хаагчдад олгож байна. Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар төрийн албан хаагчдын цалинд өөрчлөлт орсон тул даргын 2023.07.07-ны өдрийн Б/24 дүгээр тушаалаар нийт 24 албан хаагчийн цалинд өөрчлөлт оруулсан. Мөн хоол, унааны санхүүжилт нэмэгдсэнтэй холбогдуулан ажлын 8 цагийн хоолны	

				хөнгөлөлтийн 9,000 төгрөг буюу 33,33%-аар, унааны хөлсийг 1,000 төгрөг буюу 50%-аар тус тус нэмэгдүүлсэн байна. 100%	
16.	3.3.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг улиралд 1 удаа, төрийн захиргааны албан хаагчийг хагас жилд 1 удаа тус тус холбогдох журмын дагуу үнэлж, албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар	жилдээ	Албан хаагчид	Төрийн албан хаагчийн улирлын үр дүнг 01 дүгээр улирлын үр дүнг нийт 25 албан хаагчдад албан тушаалын үндсэн цалингаас 16%-40%-аар тооцон нийт 27,298,000 төгрөгийн урамшууллыг даргын тушаалаар олгосон байна. 100%	
17.	3.3.3.Өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангалттай сайн биелүүлсэн төрийн үйлчилгээний ажилтан албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг тогтоосон журмын дагуу олгох;	жилдээ	Албан хаагчид	Төрийн үйлчилгээний албан хаагчдад 25 албан хаагчдад 10%-25% хүртэл ур чадварын нэмэгдэлийг тушаалаар 25,599,000 төгрөг олгосон байна. 100%	
18.	3.3.4.Албан хаагчдын илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Засгийн газраас батлагдсан журмын дагуу тухай бүр тооцож олгох;	Тухай бүр	Албан хаагчид	ҮЭХ-той байгуулсан хамтын гэрээний дагуу гишүүдэд шөнийн цагийн хөлсийг 1,3 дахин, илүү цагийн хөлсийг 1,8% дахин нэмэгдүүлэн олгож байна. Цалингийн сан хүрэлцэхгүй үед илүү цагийн хөлсийг ажлын 2 өдрөөр тооцон ээлжийн амралт дээр нэмж олгож байна. -Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Дадлага сургууль зохион байгуулах тухай” А/332 дугаар захирамжийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд улс орон даяар зохион байгуулагдсан Стратегийн команд штабын сургуулийн Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн баримт бичгийн бүлэгт ажилласан архив, бичиг хэрэг, хүний	

				нөөцийн ажилтан Чинбатын Болдцэцэгт илүү цагийн нэмэгдэл хөлсийг даргын 2023.06.19-ний өдрийн Б/22 дугаар тушаалаар олгосон. 100%	
19.	3.3.5.Ажил хавсран гүйцэтгэсэн бол албан тушаалын үндсэн цалингийн 40% хүртэл, эзгүй байгаа ажилтны ажлыг давхар гүйцэтгэсэн бол албан тушаалын үндсэн цалингийн 20% хүртэл нэмэгдэл хөлсийг олгох	Тухай бүр	Албан хаагчид	мэргэжилтэн Ө.Билэгсайхан, архив, бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтан Ч.Болдцэцэг, сантехникч-цахилгаанчин Ж.Алтантогос нарт ажил хавсран гүйцэтгэсэний нэмэгдэл хөлсийг тухайн албан тушаалын цалингийн 40%-аар, мэргэжилтэн О.Мөнхзулд ажил гүйцэтгэсний нэмэгдэл албан тушаалын цалингийн 20%-өөр тус тус тооцон олгож байна. 100%	
20.	3.3.6.Жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96%-аас дээш хангасан төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын үндсэн цалинг 1 сар 80%-100% хүртэл 1 удаа нэмэгдүүлэн урамшуулах;	жилдээ	Албан хаагчид	Байгууллагын жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангалттай биелүүлэхэд оролцсон албан хаагчдад мөнгөн урамшуулал болгон албан тушаалын үндсэн цалингаас нийт 25 албан хаагчдад 100 хүртэлх хувийн мөнгөн урамшуулал 18,889,400 төгрөг олгосон байна.	
21.	3.3.7.Эрхэлсэн ажил албан тушаалын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдад сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх зорилгоор 1 удаа 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөг хүртэл олгох;	жилдээ	Албан хаагчид	Үндэсний техникийн их сургуульд суралцаж буй 3 албан хаагчийн хүсэлтээр сургалтын төлбөрийн дэмжлэгт даргын 2023.01.27-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар тус бүр 200,000 төгрөг, нийт 600,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. 100%	
3.4.Албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтын хүрээнд:					
22.	3.4.1.Албан хаагчдын эхнэр амаржсан бол ажлын 10 өдрийн, төрсөн үр хүүхэд нь шинэ хүүхэдтэй болсон ажилтанд ажлын 5 өдрийн	Тухай бүр	Албан хаагчид	Жолооч-жижүүр И.Тожилсүрэнгийн том хүү шинэ хүндтэй болсон тул ажлын 5 өдрийн цалинтай чөлөө олгосон.	

	цалинтай чөлөөг тухай бүр олгох;			100%	
23.	3.4.2.Шинээр гэр бүл болсон залуу гэр бүлийн баярт мөчийг хуваалцан 200,000 (хоёр зуун мянга) төгрөг хүртэл дэмжлэг үзүүлэх;	Тухай бүр	Албан хаагчид	Тухай бүр шийдүүлнэ. 100%	
24.	3.4.3.Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авах;	Тухай бүр	Албан хаагчид	Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээний талаар мэдээллийг тогтмол ажилчдад хүргэж ажилласан ба зөрчил, гомдолын мэдээлэл ирээгүй байна. 100%	
25.	3.4.4.Хамт олноо төлөөлөн аливаа уралдаан, тэмцээнд оролцож буй албан хаагчдад өдрийн хоолны мөнгийг 10,000 (арван мянга) төгрөгөөр тооцож дэмжлэг үзүүлэх ба эхний 3 байранд шалгарсан тохиолдолд амжилтыг нь урамшуулж 1 хоногийн цалинтай чөлөө олгох;	Тухай бүр	Албан хаагчид	Булган аймагт зохион байгуулагдсан Хангайн бүсийн спортын салбарын 3 төрөлт тэмцээнд оролцсон тамирчдын өдрийн хоол, байрны зардалд 540,000 төгрөг зарцуулсан байна. 100%	
26.	3.4.5.Албан хаагч 1 сараас дээш хугацаагаар хүндээр өвдсөн, гэр бүлийн гишүүн нь (гэр бүлийн гишүүн гэдэгт төрсөн үр хүүхэд, эхнэр, нөхөр, төрсөн аав, ээж орно) өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, албан хаагчийн хүсэлтийг харгалзан 1 удаагийн буцалтгүй тусламж болгон 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөг хүртэл дэмжлэг үзүүлэх, гэр	Тухай бүр	Албан хаагчид	Харуул Н.Дорждэрэм нь Улаанбаатар хотод хагалгаанд орох болсон тул даргын 2023.03.06-ны өдрийн Б/09 дүгээр тушаалаар 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 100%	

	бүлийн гишүүнээ асран хамгаалахад зориулан ажлын 10 өдрийн цалинтай чөлөө олгох;				
27.	3.4.6.Жилийн эцэст албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, дүгнэн байгууллагын “Тэргүүний ажилтан”-аар 1 хүн шалгаруулж, өргөмжлөл, 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөг хүртэл урамшуулах, орон нутгийн шагнал урамшуулал болон төрийн дээд шагналд тодорхойлох;	Жилийн эцэст	Албан хаагчид	2023 оны байгууллагын Тэргүүний ажилтнаар шалгарсан мэргэжилтэн О.Заяад 400,000 төгрөг, Биеийн тамирын тэргүүн, салбарын Жуух бичгээр шагнагдсан 4 албан хаагчид шагналын мөнгө 270,000 төгрөг тус тус олгосон байна.	100%
28.	3.4.7.Албан хаагчийн хүүхдээс олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээн, олимпиадад оролцож байр эзэлсэн тохиолдолд 100,000 (нэг зуун мянга) төгрөг хүртэл урамшуулал олгох;	Тухай бүр	Албан хаагчид	Болзол хангасан материал ирээгүй байна.	100%
29.	3.4.8.Албан хаагчийг орон байрны нөхцлөө сайжруулах зорилгоор цалингийн зээлийн хүүг бууруулах асуудлыг тухай банкинд уламжлан хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах;	Тухай бүр	Албан хаагчид	2023 онд цалингийн зээлийн хүү сарын 1,6%-байсныг 1,4%-тай болгож ХААН банкт хамтран ажиллах гэрээг шинэчилэн байгуулсан.	100%
30.	3.4.9.Хүүхдийн баяр, шинэ жилийг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдийн дунд арга хэмжээ зохион байгуулах, урамшуулах (0-18 насны хүүхдүүдэд бэлэг өгөх);	Тухай бүр	Албан хаагчид	2023 оны 06 дугаар сарын 01-ний хүүхдийн баярын өдрөөр 0-16 насны нийт 22 гарын бэлэг тус бүр 30,000 төгрөгөөр тооцон нийт 660,000 төгрөг олгосон байна.	100%
31.	3.4.10.Ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр (нөхөр) -ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд сувилуулах бол хоёр жилд нэг удаа олгох;	Тухай бүр	Албан хаагчид	Төсвийн хэмнэлтийн хуулиар хасагдсан.	100%

32.	3.4.11.Албан хаагчдын өрхийн амьжиргааг дээшлүүлэх, сайжруулах зорилгоор Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд 5 албан хаагчид павильон түрээслүүлэн гэрээ хийж худалдаа, үйлчилгээ эрхлэх зэрэг өрхийн орлогоо нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх;	Тухай бүр	Албан хаагчид	Баяр, наадмын өдрүүдэд ажиллах хүсэлт гаргасан харуул Л.Лхагвасүрэн, Ч.Эрдэнэболд нартай павильон ажиллуулах гэрээ байгуулан ажилласан. 100%	
33.	3.4.12.Албан хаагчийн төрсөн хүүхэд, ах, эгч, дүү, аав, ээж, эхнэр (нөхөр) нас барсан тохиолдолд 1 удаагийн буцалтгүй тусламж 300,000 (гурван зуун мянга) төгрөг хүртэл дэмжлэг үзүүлэх;	Тухай бүр	Албан хаагчид	Тухай бүр шийдвэрлүүлж ажиллана. 100%	
34.	3.4.13.Ажилтан албан хаагчдад өндөр үнэтэй шинжилгээ хийлгэх, эм тариа худалдан авахад зориулан эмнэлгийн бичгийг үндэслэн үнийн дүнгийн 20% хүртэлх мөнгөн дэмжлэг үзүүлэх;	Тухай бүр	Албан хаагчид	Ахлах мэргэжилтэн Д.Одгэрэлийн элэг шилжүүлэнсуулгах хагалгааны зардалд Засаг даргын нөөц сангаас 20,000,000 (хорин сая) төгрөгийн дэмжлэг олгуулсан. 100%	

35.	3.4.14.Бусад дэмжлэг, буцалтгүй тусламжийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад дүрэм, журмын дагуу хэрэгжүүлнэ.	Тухай бүр	Албан хаагчид	-Жижүүр Т.Насанбат нь өндөр настаны тэтгэвэрт гарсан тул хуулийн дагуу төрийн албанд ажилласан хугацааны нэг удаагийн тэтгэмжийг даргын 2023.01.27-ны Б/05 дугаар тушаалаар 12,561,700 төгрөг олгосон. -Ахлах мэргэжилтэн Д.Одгэрэлд Улаанбаатар хотод үзлэг шинжилгээнд орох үед нь даргын 2023.04.07-ны өдрийн Б/15 дугаар тушаалаар ажлын 7 өдрийн цалинтай чөлөө олгосон.	100%
3.5.Албан хаагчдын орон сууц, амьдрах орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд;					
36.	3.5.1.Албан хаагч гэр бүлийн хэрэгцээний газар өмчлөх, зуслангийн газар шинээр эзэмшихэд холбогдох байгууллагад уламжлах, хамтран ажиллах;	жилдээ	Албан хаагчид	Булган аймгийн Бугат суманд газар эзэмших 25 албан хаагчийн өргөдөлийг хүргүүлээд байна.	80%
37.	3.5.2.Албан хаагчдын орон сууцны нөхцлийг сайжруулж тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор түрээсийн орон сууцны, хямд үнээр орон сууцжуулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хамруулах, орон сууцны нөхцөлөө сайжруулсан албан хаагчтай тогтвортой ажиллах гэрээ байгуулах;	жилдээ	Албан хаагчид	Аймгийн хэмжээнд түрээсийн орон сууцны хөтөлбөр хэрэгжээгүй байна.	0%
38.	3.5.2.1.Түрээсийн орон сууц болон хямд үнэтэй орон сууцны төсөл хөтөлбөрт хамруулах, холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх;	жилдээ	Албан хаагчид	Аймгийн хэмжээнд түрээсийн орон сууцны хөтөлбөр хэрэгжээгүй байна.	0%

39.	3.5.2.2.Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад нь зориулан 200,000 (хоёр зуун мянга) хүртэл мөнгөн дэмжлэг үзүүлэх;	10 дугаар сард	Галлагаатай байранд амьдардаг албан хаагчид	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад нь зориулан даргын 2023 оны Б/36 дугаар тушаалаар нярав Э.Баасанням, харуул Д.Жаргалсайхан нарт тус бүр 180,000 төгрөг, нийт 360,000 төгрөг олгосон.	100%
3.6.Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, өөрийгээ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:					
40.	3.6.1.Байгууллагын захиалга болон өөрсдийн саналаар мэргэжил эзэмших, мэргэшлээ дээшлүүлэх, өөр мэргэжил эзэмшихээр сургалтад хамрагдвал холбогдох баримт бичгийг үндэслэн цалинтай чөлөө олгох;	Тухай бүр	Албан хаагчид	Хууль эрхзүйн оройн ангид цахимаар суралцаж байгаа архив, бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтан Ч.Болдцэцэгт хичээл, сургалтын үед ажлын цагийг 1-2 цагаар тухай бүр богиносгон чөлөө олгож ажилласан.	100%
41.	3.6.2.Ажилтан албан хаагчдад богино хугацааны сургалтад хамрагдвал томилолтын зардал эсвэл сургалтын төлбөрийн зохих хэсгийг олгох;	Тухай бүр	Албан хаагчид	2023 оны 04 дүгээр сарын 26-27-ны өдөр “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх сургалтад оролцсон 5 албан хаагч дарга Д.Дэлгэрбаяр, ахлах мэргэжилтэн Э.Лхамсүрэнбаатар, мэргэжилтэн М.Ариун-Эрдэнэ, Ө.Билэгсайхан, О.Заяа нарт томилолтын зардал нийт 994,000 төгрөг олгосон.	100%
42.	3.6.3.Ажилтан албан хаагч 3 сараас дээш 1 жил хүртэлх сургалтад хамрагдсан тохиолдолд ажлын байр, албан тушаалыг нь ажилтантай тохиролцон хэвээр хадгалах, цалингүй чөлөө олгох;	Тухай бүр	Албан хаагчид	Ажилтан албан хаагчдаас хүсэлт ирээгүй, суралцаж байгаа ажилтан албан хаагч байхгүй байна.	100%
Хэрэгжилтийн нийт хувь					94,00%

